

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	8
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	27
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд.....	3
Хүснэгт 2. Сайн хөөврийн ил уурхайн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	4
Хүснэгт 3. Уурхайн ашиглалтын технологийн схем	5
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	21
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт.....	27
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	30
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	33

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын зураг.....	3
--------------------------------------	---

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн нэр: “Сайн Хөөврийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл”

Төсөл хэрэгжүүлэгч: “Бадмаарагхаш” ХХК /регистрийн дугаар: 5215919, улсын бүртгэлийн дугаар: 9019039141, албан ёсны хаяг: Баянзүрх, 18-р хороо, 13-р хороолол, 11-64, утас: 99008536/

Төслийн байршил: “Сайн Хөөвөр”-ийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Сайн Хөөвөр” хэмээх газарт хэрэгжих бөгөөд MV-016679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь нийт 755.55 га талбайг хамарна.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд

Булангийн цэгийн дугаар	Уртраг, E	Өргөрөг, N
1	115° 21'33.78”	45°28 '51.31”
2	115°21'33.78”	45°28'31.66”
3	115°22'50.78”	45°28'31.66”
4	115°22'50.77”	45°27' 1.67”
5	115°20'54.19”	45°27' 1.67”
6	115°20'54.19”	45°28'51.31”



Зураг 1. Төслийн байршилын зураг

Ордыг ашиглах тусгай зөвшөөрөл: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Сайн Хөөвөр” нэртэй газарт хайгуул хийх тусгай зөвшөөрлийг 2008 онд

“Дэвжих трейд” ХХК-иас шилжүүлэн авсан бөгөөд улмаар 755.55 гектар талбайд нь ашиглалтын MV-016679 тоот тусгай зөвшөөрөл авсан.

АМГ-ын ГУУКХ-ийн даргын 2010 оны 09 сарын 30-ны өдрийн 1035 тоот шийдвэрээр MV- 16679 ашиглалын лицензийн талбайг 9011148038 тоот улсын бүртгэлийн дугаартай “Бадмаарагхаш” ХХК-д олгосон. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Сайн хөөвөр” нэртэй 755.55 га талбайд ашигт малтмал ашиглах 16679А дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон. 2013 оны 9-р сараас эхлэн ТЭЗҮ-ийн дагуу “Сайн хөөвөр”-ийн ордод уурхай байгуулалтын ажил хийгдэж нүүрс олборлолт эхэлсэн.

“Бадмаарагхаш” ХХК нь “Сайн хөөвөр”-ийн нэртэй талбайд хүрэн нүүрсний олборлолт явуулж, дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх зорилгоор бэлтгэл ажлаа бүрэн хангаж дуусгасан бөгөөд 2012 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Уурхайг хүлээн авах улсын комисс газар дээр нь ажиллаж, №12/08 тоот актаар холбогдох зөвшөөрлийг олгосноор ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлсэн юм.

Хүснэгт 2. Сайн хөөврийн ил уурхайн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд		Нэгж	Тоон утга
1	"Сайн хөөвөр" ордын геологийн нөөц	В нөөц	мян.тн	25433.4
		С нөөц	мян.тн	19121.0
		В+С	мян.тн	44554.4
2	Ордын нүүрсний нөөц /2018.01.01 байдлаар/	В нөөц	мян.тн	25176.8
		С нөөц	мян.тн	19098.3
		В+С	мян.тн	44275.1
3	Уурхайн хүрээ хязгаарт орох нөөц	В нөөц	мян.тн	24913.4
		С нөөц	мян.тн	17341.6
		В+С	мян.тн	42254.9
4	Олборлолтын үеийн хаягдал		%	7.0
5	Олборлолтын үеийн бохирдол		%	5.6
6	Үйлдвэрлэлийн нөөц	Эцсийн байдлаар	мян.тн	41497.7
		10 жил	мян.тн	14700.0
7	Хөрс хуулалт	Эцсийн байдлаар	мян.м ³	80313.4
		10 жил	мян.м ³	28547.2
8	Хөрс хуулалтын дундаж коэффициент	Эцсийн байдлаар	м ³ /тн	1.94
		10 жил	м ³ /тн	1.94
9	Жилийн нүүрс олборлолт		сая тн	1.2-1.5
10	Уул-тээврийн үндсэн тоног төхөөрөмж:	Марк	Х.н	-
	Экскаватор	Hyundai R520LC-9S	ш	10
	Автосамосвал	Shacman F3000	ш	22
		Shacman F2000	ш	12
	Бульдозер	Cat D8	ш	3
	Утгуурт ачигч	Luigong-888	ш	3
		ZL-50	ш	2
	Авто грейдер	LIUGONG CLG 422	ш	1
	Усны машин	Howo 15тн	ш	2
	Түлшний машин	Sinotruck 15тн	ш	1

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах “Бадмаарагхаш” ХХК-ийн “Сайн хөөвөр” хүрэн нүүрсний ордын 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

	Үйлчилгээний машин	Pick up	ш	3
		УАЗ фургон	ш	2
	Насос	ЦНС-300-120	ш	3
	Гүний насос	ЭЦВ10-63-65	ш	3
	Дизель станц	QAS100	ш	4
		QAS200	ш	2
11	Төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ		сая төг	29183.2

Ашиглалтын технологи:

Уг төслийн нүүрс олборлолтын жилийн хүчин чадал дунджаар 1 сая орчим тонн нүүрс бөгөөд нийтдээ 25-28 жилийн хугацаанд төслийн үйл ажиллагаа үргэлжилнэ гэж урьдчилсан байдлаар тооцсон байсан ч нэмэлт хайгуулын ажлаар ордын нүүрсний нөөц өссөөр байгаа тул энэ хугацаа нэмэгдэх боломжтой болж байгаа юм. “Бадмаарагхаш” ХХК нь төлөвлөгөөт онд нийт 11 ажлын байранд 150 хүн ажиллуулахаар төлөвлөсөн.

Нүүрсний давхаргууд нь газрын гадаргад ил гарштай, цул үргэлжлэн тогтсон, хагаралд харьцангуй бага өртсөн байдаг. Ордын уул техникийн нөхцөл, эдийн засгийн зохистой хэмжээ зэрэгт үндэслэн ордыг ил аргаар, гадаад болон дотоод овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгагдсан.

Хүснэгт 3. Уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	-Ухаж ачих -Тээвэрлэх -Овоолох
	Олборлолт	-Ухаж ачих -Тээвэрлэх -Овоолох

“Сайн хөөвөр”-ийн ордыг 2012 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд уулын ажлаар нийт 4974.0 мян.м³ хөрс хуулж уурхайн нээлтийг гүйцэтгэсэн одоогийн байдлаар 0.45 сая.тн нүүрс нээгдсэн байгаа юм. Иймд ордын ашиглах дарааллыг уурхайн жилийн хүчин чадал, хөрс хуулалт, нүүрсний давхаргын тогтоц, тээвэрлэлтийн зай, ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдээс үндэслэн дараах байдлаар тогтоосон. Бадмаарагхаш ХХК нь “Сайн хөөвөр” нүүрсний ордод нийт 3 хэсгээс уурхайлан олборлож байна.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уур амьсгалын үндсэн нөхцөл Төслийн объект байрших нутаг газарзүйн хувьд Монголын Дорнодын талархаг мужид хамаарах бөгөөд Дорнодын талархаг их муж дотроо дов толгодот талын, тэгш талын, Хянганы гэсэн гурван мужид хуваагдах бөгөөд Монголдоо хамгийн нам дор орших нутаг юм. Монголын Дорнод тал урдуураа далайн түвшнээс 1000-1500м хүртэл өргөгдсөн, хойшоо болох тутам намассаар Буйр нуурын орчим 583 м хүртэл доошлоно.

Агаар мандлын тогтворшлын явцтай уялдан Монгол оронд хүчтэй салхи сайтар илэрсэн хоногийн явцтай. Өдрийн цагт өнгөн хөрс, тэр хавийн агаарын доод нимгэн үе давхрага хүчтэй халж, эрчлэл солилцоо идэвхжиж, шөнө салхины хурд 15 м/с хүрэхгүй байсан даралтын шатлууртай нөхцөлд өдрийн цагт 15 м/с ба үүнээс хүчтэй салхи гарна. Өдрийн 12-15 цагийн хооронд нийт хүчтэй салхины 23.4% нь тохиолдож байхад шөнө 3-6 цагийн хооронд дөнгөж 5.8% нь оногдоно. Өглөөний 6 цагаас оройн 20 цагийн хооронд хоногийн бүх хүчтэй салхины 71.2%. 9-18 цагийн хооронд 58.4% нь ажиглагдана. Хүчтэй салхины жилд үргэлжлэх хугацааг авч үзвэл Эрдэнэцагаанд 104 цаг, Эрдэнэцагаанд 62 цаг болно. Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун, баруун хойд чиглэлийн салхи зонхилно.

2019 оны 05 дугаар сарын агаарын дундаж температур нийт нутгаар /13.30 14.10/ дулаан байсныг уур амьсгалын дундажтай харьцуулж үзэхэд нутгийн ихэнх хэсэг буюу Асгат, Наран, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Уулбаян, Халзан сумдын нутгаар /1.00...1.70/-аар дулаан бусад сумдын нутгаар дундажын орчим байлаа. Агаарт хамгийн их дулаан /25.70...29.10/ хүрч халсан ба 30.00-с давж 1-3 өдөр халсан байна. Хөрсний гадаргын дундаж температур /13.70 20.60/ дулаан. Хамгийн их дулаан /42.10 49.30/ халсан ба 40.00-с давж 3-18 өдөр халсан байна. Салхины их хурд 24-28 м/сек хүрч 10 м/сек-с давж 10-22 өдөр, 6 м/сек-с давж 20-31 өдөр салхилсан ба 4,6,9,11,15,17,19-ны өдрүүдэд өдрүүдэд аймгийн ихэнх нутгаар салхины дундаж хурд 15 м/сек-с давж хүчтэй салхи болон шороон шуурга шуурсан байна. Энэ сард нийт нутгаар 0.0 34.1 мм хур тунадас орсонг уур амьсгалын дундажтай харьцуулж үзэхэд Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон сумдын нутгаар дундажаас ахиу бусад сумдын нутгаар дундажаас бага хур тунадас орсон байна. Бэлчээрийн ургамлын ургалтын байдал нийт нутгийн 8 хувьд хэвийн, 33 хувьд дунд, 59 хувьд муу байна.

Агаарын чанар 2019 оны 08-р сарын 10-аас 12-ний өдрүүдэд орчны судалгааны ажлын хүрээнд нийт 2 ажиглалтын цэгээс (АЧ-1, АЧ-2) түгээмэл бохирдуулагчид болох хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийснээс гадна 2.5 болон 10 микроноос бага хэмжээтэй тоосны хэмжилтийг хийв. Суурь судалгааны агаарын чанарын ажиглалтын цэгүүд дээр гол төлөв судлагдаж буй нутаг дэвсгэрийн орчны онцлог байдлыг төлөөлж чадахуйц хэсгүүдийг сонгон авсан ба хайгуулын талбайн хүний хүчин зүйлийн нөлөөлөлд өртөмхий боловч байгалийн тогтоцоороо байгаа зэргээс хамаарч ажиглалтын цэгүүдэд орчны бохирдлын байдал, тэдгээрийн явцыг хянах олон удаагийн шинжилгээ хийх шаардлагагүй байсан бөгөөд тандалт хийх зорилгоор 1 удаагийн хяналт- шинжилгээ хийж агаарын чанарын нөлөөллийг үнэлэлээ. Агаарын чанарын үзүүлэлтүүдийг нэгтгэн агаарын бохирдлын индексийг (АБИ) тооцсон дүнг хүснэгтэд үзүүлэв. АБИ тооцсон дүнгээр хайгуулын талбайн агаарын чанар судалгаа хийх хугацаанд цэвэр ангилалд хамаарч байна.

Төслийн талбайн агаарын чанарын судалгааны дүнг бүхэлд нь авч үзвэл уг талбайн хэмжээнд одоогийн байдлаар агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд тосны замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн хий болон зорчих үед сайжруулсан хөрсөн замын гадаргуугаас үүсэх тоос, тоосжилт болон хилийн заставын орчмын хөрсөн замууд нийтлэг бохирдуулагчид хамаарч байна. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдтэй боловч агаарын бохирдол үүсгэх зай харьцангуй бага ба тээврийн замаас алслагдсан цэгүүдэд агаарын чанар цэвэр ангилалд хамаарна. Судалгааны нутагт хийгдсэн агаарын шинжилгээний дүнгээр агаар дахь хүхэрлэг ангидридын агууламж $0.002-0.003 \text{ мг/м}^3$, азаотын давхар ислийн агууламж $0.008-0.01 \text{ мг/м}^3$, том ширхэгт тоосонцрын агууламж $0.018-0.023 \text{ мг/м}^3$, нарийн ширхэгт тоосонцрын агууламж $0.012-0.023 \text{ мг/м}^3$, хэмжээнд хэлбэлзэж байгаа ба эдгээр агууламжийг хайгуулын талбайн агаарын чанарын фон агууламж гэж үзэж болох юм.

Ордын гидрогеологийн нөхцөл: Нүүрс агуулагч хурдас нь элсэн чулуу, алевролит, гравеллит, конгломерат зэрэг терриген гаралтай чулуулгаас бүрэлдэх ба нүүрсний гол давхаргууд нь элсэн чулууны үе дотор байна.

Нүүрс агуулагч хурдас нь ордын нийт талбайд дөрөвдөгчийн элс, шавранцар, гравий, галькаас бүрдсэн сэвсгэр хурдсаар хучигджээ. Хучиж буй дөрөвдөгчийн хурдасны литологи бүрэлдэхүүнийг үзэхэд уг хурдас нь хур тунадасны ус нэвчин шингэхэд тохиромжтой болно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал: Уурхайн үйл ажиллагааны ил уурхай, үйлдвэр, зам, хөрсний овоолго зэрэг талбайг хамарсан эвдрэл үүсч байгаль орчинд сөрөг нөлөө учруулна. Ордыг ашигласнаар газрын гадаргууг тодорхой хэсэгт өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, гидрогеологийн горимыг өөрчилдөг.

Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Нүүрсны ордыг олборлох, тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын хими болон физик шинж чанарт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно. Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Ил уурхайн хил хязгаар дотор Сайн хөөврийн хүрэн нүүрсний уурхайг олборлоход хөрсний бүтэц, үржил шимт чанарыг алдагдуулна.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана
- Нүүрсийг тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл:

- Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордын ил уурхайн ашиглалтын хугацаанд 140 орчим метр гүн ухах ба уурхайн талбайд шүүрэн орж ирэх усны хэмжээ 3,45 л/сек

байх бөгөөд уурхайд орж ирэх хур тунадасны хэмжээ 192,5 м³/цаг байна. Тиймээс талбайн усыг бүрэн шүүрүүлж, хуурайшуулах үйл ажиллагааг явуулах ба ус цуглуулагч зумпф байгуулан усыг төвлөрүүлж насосоор дээш гарган ус зайлуулах суваг руу хүргэж усалгаа чийгшүүлэлтэд ашиглана. Энэ усыг хадгалахын тулд, хуримталсан ус уурхайн талбай руу буцаж шүүрэхгүй газрыг сонгон шүүрүүлэлтийн цөөрөм байгуулна. Өөрөөр хэлбэл, цөөрмийн ёроол хэсэг нь ус муу нэвчих давхаргатай, өндөржилт ихтэй хэсэг нь уурхайн талд байрласан, уурхайн талбай руу чиглэсэн гуу, жалгагүй байвал зохино.

- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт нөлөөлөх нөлөөлөл: Сайн хөөврийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, үүний хамтаар, уурхайн үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшсэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм. Иймд төслийн талбайг эзэмших, уурхайн үндсэн ба туслах үйл ажиллагааг эхлэх хугацаа, горимыг дээрх нөхцөл байдалтай уялдуулан нарийн төлөвлөх, орон нутгийн ан амьтан

хамгаалах, малчдын нөхөрлөл, санаачлагуудтай, шаардлагатай гэж үзвэл, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч уулын ажлын үед дагаж мөрдөх хамтарсан төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд :

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр удирдан хязгаарлах нь нутгийн газар ба хөрс, ургамал, амьтдыг хамгаалах нэгэн төрлийн арга хэмжээ болно.

Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх зүйлүүдийн тоо өсөх магадлалтай.

Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл: Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг ажлууд багтсан бөгөөд 46.8 сая.төг зарцуулахаар төсөвлөсөн байна.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: - Уурхайн олборлолтын үеийн хөрс	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	бүрэн хэрэгжсэн	Уурхайн олборлолтын үе шат, бороо ороогүй, салхи ихтэй үедэд зам талбайн усалгааг хийж гүйцэтгэсэн.	
2	хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд	Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	бүрэн хэрэгжсэн	Нийт ажиллагсад тоосноос хамгаалах амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангаж ажилласан.	

3	явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	бүрэн хэрэгжсэн	Уурхайн автомашин, техникийн үзлэгийг тогтмол хийж, эвдрэл гэмтэлтэй машин механизмыг ажилд гаргалгүй засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэсэн.	
4	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Асгаралтын үе хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах	бүрэн хэрэгжсэн	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлж тус тусад нь хадгалж байна.	

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах “Бадмаарагхаи” ХХК-ийн “Сайн хөөвөр” хүрэн нүүрсний ордын 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

5	Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, авто зогсоолыг тэмдэгжүүлэх	бүрэн хэрэгжсэн	Техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутаар явуулж анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.	
6		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	бүрэн хэрэгжсэн	Төслийн үйл ажиллагааг төлөвлөлт, стандартын дагуу явуулж, хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хурааж ажилласан.	

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах “Бадмаарагхаа” ХХК-ийн “Сайн хөөвөр” хүрэн нүүрсний ордын 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

7	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	бүрэн хэрэгжсэн	Буйр нуур, мэнэнгийн тал газрын захиргаатай ус ашиглах гэрээг 2024 оны 06 сарын 24-ний өдөр байгуулсан.	 Батлав. Буйр нуур, мэнэнгийн талын газрын захиргааны дарга Ш.ХАНГАРЬД Батлав. “Бадмаараг” ХАШ/ХХК-ийн САВ Гүйцэтгэх захирал Г.ОХИРБААТАР УС АШИГЛАХ ГЭРЭЭ Дугаар 05 Чойбалсан хот Нэг. Ерөнхий зүйл Монгол улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7; 29 дугаар зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 101 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт”, Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны даргын 2024 оны 06-р сарын 24-ны өдрийн А/12 дугаар тушаалаар олгосон “Ус ашиглуулах зөвшөөрөл”-ийг үндэслэн. Ус ашиглуулагчийг төлөөлж: Буйр нуур-мэнэнгийн талын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний усны асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Болорчимэг. Ус ашиглагчийг төлөөлж: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт дэвсгэрт нүүрс олборлолт явуулж байгаа МУ-016678 тоот тусгай зөвшөөрөлт буюу 9010039141 улсын бүртгэлийн дугаартай, 6215919 регистрийн дугаартай “Бадмаараг хаа” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Манлайбаатар нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2024 оныг дуусгал хугацаатай байгуулав. Хоёр. Гэрээний гол нөхцөл 2.1. Ус ашиглах зориулалт: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших МУ-016678 тоот тусгай зөвшөөрөлттэй “Бадмаараг хаа” ХХК-ийн хүрэн нүүрсний ордын үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд болон унд ахуй, шавхан зайлуулах хэрэгцээнд, зам талбайн усалгаа тоосжилт дарах (шавхан зайлуулсан уснаас) усны нөөцийг ашиглахаа. 2.1.1. Байгаль, орчин, ногоон хөгжил, асгал жуулчлалын Сайдан 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.4-т заасны дагуу 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Буйр нуур-мэнэнгийн талын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүнхэх хуудсыг батлааажуулна. 2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 105,667.5 м³ 2.2.1. Үнд -ахуйн 8,212.5 м³ 2.2.2. Уурхайн шургалтаар орж нрэх усны хэмжээ – 97,236.0 м³ - Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус-34,128.0 м³ /шургилийн усыг эргүүлэн ашиглах/ 2.3. Усны чанар, найрлага: Үнд ахуйн хуулийн үснээс, шавхан зайлуулах уснаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Буйр нуур-мэнэнгийн талын сав газрын захиргаанд ирүүлнэ. 2.4. Усны эх үүсвэрийн:
8	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	бүрэн хэрэгжсэн	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын сараа, гал унтраагч зэргийг авч шаардлагатай газруудад байршуулсан.	

					
9		Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал	бүрэн хэрэгжсэн	Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг зэргийн ариутгал, орчны цэвэрлэгээг тогтмолжуулсан.	

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд 2024 оны БОМТ-нд нөхөн сэргээлтийн төлөвлөгөө тусгагдаагүй бөгөөд биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний хүрээнд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Аймаг орон нутгаас санал авсан талбайд дүйцүүлэн хамгаалах ажлыг хийх	бүрэн хэрэгжсэн	Зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэх зорилгоор Халиун буганд био техникийн арга хэмжээ авах буюу хужир шүү тавьж өгөх ажлыг Бадмаарагхаш ХХК-ны захиалгаар хийж гүйцэтгэж ажиллалаа.	 
2	Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох; Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	бүрэн хэрэгжсэн	Тус ажлыг 2024 оны 10 сарын 18-аас эхлэн 5 хонгийн хугацаанд гүйцэтгэсэн болно. Эрдэнэцагаан сумын нутаг 7 дугаар багийн нутаг Лагийн улаан хонхор / N46°35'22", E116°18'592"/ гэдэг газраас 1-р багийн нутаг Лхачинвандад уул, Хэцүү жанжин, зэрэгт газарт нутаглаж буй зэрлэг ан амьтанд нийт 10 тонн хужир шүү татаж бугын сүргүүдэд тарааж байлуулсан.	  20-Oct-2024 23:25:11 N 45° 41' 32", E 116° 8' 24" 327° NW Altitude: 1014.9meter Speed: 1.5km/h

3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	бүрэн хэрэгжсэн	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд шинэ ногоон байгууламжийн талбай байгуулж 200 улиас, кемпийн гадаа 1000 хайлаас, 1000 шар хуайс, 22 агч тарьсан мөн суманд 200 улиас өгсөн.	
---	---	-----------------	--	--

				
--	--	--	--	--

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Бадмаарагхаш” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол,сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл																																								
1	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	бүрэн хэрэгжсэн	Цаг агаарын мэдээг байнга авч болзошгүй осол эрсдэлээс хамгаалах, гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулсан.	 Бадмаараг хаш ХХК-ны гамшиг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс 2024.09.07 <table><tr><th>№</th><th>Нэр</th><th>Албан тушаал</th><th>Гарын үсэг</th></tr><tr><td>1</td><td>О.Халиунсарнай</td><td>Байгаль орчны мэргэжилтэн</td><td></td></tr><tr><td>2</td><td>Д.Мандах-Оргил</td><td>Мэдээ бэлтгэгч</td><td></td></tr><tr><td>3</td><td>Ч. Хөгжил</td><td>Нярав</td><td></td></tr><tr><td>4</td><td>Н. Барсбаатар</td><td>Маркшейдер</td><td></td></tr><tr><td>5</td><td>М. Эрдэнэбаатар</td><td>Ковш оператор</td><td></td></tr><tr><td>6</td><td>А. Мөнхсолоongo</td><td>Тогооч</td><td></td></tr><tr><td>7</td><td>Н. Мөнхтуяа</td><td>Үйлчлэгч</td><td></td></tr><tr><td>8</td><td>М. Наранцаг</td><td>Галч</td><td></td></tr><tr><td>9</td><td>Б. Оюунжаргал</td><td>Тэргүүн нандин хөрс ХХК</td><td></td></tr></table>	№	Нэр	Албан тушаал	Гарын үсэг	1	О.Халиунсарнай	Байгаль орчны мэргэжилтэн		2	Д.Мандах-Оргил	Мэдээ бэлтгэгч		3	Ч. Хөгжил	Нярав		4	Н. Барсбаатар	Маркшейдер		5	М. Эрдэнэбаатар	Ковш оператор		6	А. Мөнхсолоongo	Тогооч		7	Н. Мөнхтуяа	Үйлчлэгч		8	М. Наранцаг	Галч		9	Б. Оюунжаргал	Тэргүүн нандин хөрс ХХК	
№	Нэр	Албан тушаал	Гарын үсэг																																										
1	О.Халиунсарнай	Байгаль орчны мэргэжилтэн																																											
2	Д.Мандах-Оргил	Мэдээ бэлтгэгч																																											
3	Ч. Хөгжил	Нярав																																											
4	Н. Барсбаатар	Маркшейдер																																											
5	М. Эрдэнэбаатар	Ковш оператор																																											
6	А. Мөнхсолоongo	Тогооч																																											
7	Н. Мөнхтуяа	Үйлчлэгч																																											
8	М. Наранцаг	Галч																																											
9	Б. Оюунжаргал	Тэргүүн нандин хөрс ХХК																																											
2		Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	бүрэн хэрэгжсэн	Осол эрсдэлээс хамгаалах сургалтыг ажилчдад зохион байгуулж, уурхайн ажилчдад хөдөлмөр аюулгүй байдлын сургалтанд хамруулсан.																																									

3		Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	бүрэн хэрэгжсэн	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэлтэй болсон.	
4		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	бүрэн хэрэгжсэн	Байгаль орчныг хамгаалах сургалтыг нийт ажилчдын дунд хийж, өдөр тутмын заавар зааварчилгаагаар хангаж ажилласан.	

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах “Бадмаарагхаи” ХХК-ийн “Сайн хөөвөр” хүүрэн нүүрсний ордын 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан


5 Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	бүрэн хэрэгжсэн	Нийт ажилчдыг эрүүл мэндийн багц шинжилгээнд 2024 оны 08 сарын 07-ний өдөр хамруулсан.	БАТЛАВ. ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛЫН ОРЛОГЧ ДАРГА  БАТЛАВ. "ДАРХАН ДЕТЕКТ" ХХК ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ  ЭМНЭЛГИЙН БАГЦ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ ГЭРЭЭ 2024 оны 08-р сарын 07-ны өдөр Дугаар: 2408/07 Улаанбаатар хот Энэхүү Эмнэлгийн багц шинжилгээ хийлгэх гэрээ ("Гэрээ") 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр: 1) Параситес ХХК (Регистрийн дугаар: 6276761) ("Үйлчилгээгч") болон 2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Дархан детект" ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 000252915, регистр 4251172) ("Эмнэлэг") нар /амтал нь "Талууд" г.м/ нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн дараах нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав. Нэг. Нийтлэг үндэснэл 1.1 Энэхүү гэрээний гол зорилго нь Эмнэлэг нь Үйлчилгээгчийн хүснэгтээр түүний ажиглуулах ба ерөнхий оношилгооны багцын үзлэг, шинжилгээг хийн онои, нэгдсэн дүгнэлт, тайлан гаргах, Үйлчилгээгч нь Эмнэлэгт нэгдсэн дүгнэлт, тайланг хүлээн авч түүнд үйлчилгээний хэлс төлөөллийг хэлбэлсгэсэн тус харилцан зохихуулахад оршино. Хоёр. Гэрээний хугацаа 2.1. Гэрээний хугацаа нь 2024 оны 08-р сарын 07-ны өдөрөөс 2024 оны 09-р сарын 30-ний өдрийг дуусгал. Энэхүү хугацааны хүрээнд талууд үзлэг, шинжилгээ хийх тодорхой хугацааг тус тус тохиролцоно. Гурав. Төлбөрийн хэмжээ, түүнийг хийх журам 3.1 Шинжилгээнд нийт 28 ажиглан хамрагдах ба шинжилгээний төлбөр хувий тус бүр 223000 болно. Нийт төлбөр 6,244,000 (зургаан сая хоёр туун дөчин дөрвөн мянга) /НӨАТ орсон/ тоглог болно. 3.2 Үйлчилгээгч үзлэг, шинжилгээг хийлгэх ажиглуулахын төл, хийлгэх хугацааны талаар тухай бүр Үйлчилгээгчид бичгээр илгээж, энэ талаар бичгээр зөвшилцнэ. 3.3 Эмнэлэг энэхүү гэрээний 3.2-т заасан асуудлаар зөвшилцож, хариу үйлчилгээгчид бичгээр ирүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор шинжилгээнд хамрагдахын өмнө урьтчилгаа 50%, шинжилгээнд хамрагдсны дараа үлдэгдэл 50% төлбөрийг эмнэлгийн ХУДАЛДАА ХОГЖЛИЙН БАНК 472082037 тоот дансанд шилжүүлнэ. 3.4 Энэхүү гэрээний 3.1-д зааснаас хэтэрсэн үзлэг, шинжилгээг хийлгэх тохиолдолд тухайн ажиглан өөрөө төлбөрийн зөрүүг хариуцана. 3.5 Талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэхгүй бол хугацаа хэтэрснэ хонго тутамд гүйцэтгэхгүй үүргийн 0.5 хувийн алданыг Эмнэлэгт тално.
----------------------------	--	------------------------	---	---

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
